



**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY**



**ШУТИС-203**   
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Улаанбаатар  
2024**

## АГУУЛГА

- 4 ӨМНӨХҮГ
- 13 ХУРААНГУЙ
  
- 15 **БҮЛЭГ I. МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ШИНЭЧЛЭХ ҮНДЭСЛЭЛ**
- 16 1.1. ШУТИС-ИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ
- 18 1.2. ШУТИС-ИЙН ОЛОЛТ АМЖИЛТ
- 26 1.3. “ШУТИС-2030” МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2020-2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТ
  
- 29 **БҮЛЭГ II. “ШУТИС-2030” СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ, ХАМТЫН ОРОЛЦОО**
  
- 33 **БҮЛЭГ III. ШУТИС-ИЙН ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ**
  
- 37 **БҮЛЭГ IV. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ (SWOT ШИНЖИЛГЭЭ)**



- 53 БҮЛЭГ V. СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ**
- 54 СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ – 1: СУРГАЛТЫН ШИНЭЧЛЭЛ**
- 56 СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ – 2: СУДАЛГААНЫ ТӨГӨЛДӨРШИЛ**
- 58 СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ – 3: ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ АРИЛЖААЛАЛТ**
- 60 СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ – 4: НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ТҮНШЛЭЛ**
- 63 СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ – 5: ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧЛЭЛ**



## ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн хамт олон, профессор багш, ажилтан, оюутан, суралцагч, дэмжигч, хамтран ажиллагч байгууллагын эрхэм та бүхэнд шинэчлэгдэн боловсруулагдсан “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөө, эрхэм зорилго, зорилтоо танилцуулж байна.

Манай сургууль өнгөрсөн түүхт 65 жилийн хугацаанд эх орны их бүтээн байгуулалт, аж үйлдвэрийн салбаруудыг бэхжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, шинжлэх ухаан, технологи, эдийн засаг, нийгэм, хүмүүнлэг, бизнесийн салбаруудыг хөгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулсаар ирсэн билээ.

Монгол Улсын Засгийн газар өнгөрсөн 2023 онд шинэ зуун, шинэ боловсролын эхлэлийг тавьж, түүхэндээ анх удаа Боловсролын хуулийг багцаар нь өөрчлөн, шинэчлэн баталсан. Боловсролын багц хууль, урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, боловсролын салбарын орчин үеийн өөрчлөлт шинэчлэл, их дээд сургуулийн эрэмбэ, чансаа, их сургуулийн удирдлагын менежментийн өөрчлөлт шинэчлэлтэй уялдуулан, ШУТИС-ийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, стратегийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг дахин тодорхойлох хэрэгцээ шаардлагад тулгуурлан ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсрууллаа.

ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөг шинэчлэн батлах ажлын хэсгийг профессор багш, захиргааны алба, нэгжийн дарга болон ажилтнуудын олон талт төлөөлөл бүхий 23 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, бүтэн жилийн хугацаанд их сургуулийн профессор багш, ажилтан, оюутан суралцагсдын оролцоонд тулгуурлан тэдний санал, санаачилгуудыг тусган их сургуулийн хөгжлийн бодлогын баримт бичиг бэлэн боллоо.

Энэхүү хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад сэтгэл зүрхээ гарган, хичээнгүйлэн хамтарч ажилласан бүх хүмүүст талархал илэрхийлье.



Мэдлэгт суурилсан нийгэм, ур чадвартай зөв монгол хүнийг төлөвшүүлэхэд Шинжлэх ухаан, технологийн их сургууль олон чиглэлээр тэргүүлэн, манлайллыг үзүүлж, 2030 онд дэлхийн шилдэг сургуулиудын эгнээнд багтаж, дэлхийн жишигт нийцсэн их сургууль болон хөгжих, Монгол улс, төр, нийгэм, бизнес, аж үйлдвэрийн салбарын өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэгч нь байх зорилго, зорилтууд дэвшүүлсэн.

Сургалтад суурилсан тогтолцооноос орчин үеийн судалгаанд суурилсан их сургуулийн түвшинд аажмаар амжилттай шилжиж, дэлхийн шилдэг их сургуулийн нэг болж улс орны ирээдүйн цаашдын хөгжилд бодит хөдөлгөгч хүч байхыг ШУТИС зорьж, тэмүүлж байна.

Улс орны үнэт баялаг болсон ирээдүйн инженер, мэргэжилтнүүдийг дэлхийн шинэ дэвшилтэт технологийн хөгжилтэй уялдуулан эдийн засаг, нийгэм, аж үйлдвэрлэлийн эрин үед тавигдах шаардлага, олон талын мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалтын агуулга, хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, улмаар төгсөгч мэргэжилтэн нь улс орны ирээдүйн хөгжилд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэгч нь байх зорилгыг тавив.

Сайн засаглалыг бэхжүүлж, хамт олны гишүүн нэг бүрийн мэдлэг, ур чадвар, бүтээлч сэтгэлгээ, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар нэгдмэл зорилготойгоор төлөвлөсөн зорилтуудаа хэрэгжүүлэх нь гарцаагүй. Нөгөө талаас төрийн тууштай дэмжлэг шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд төр - их сургууль – аж үйлдвэр, бизнесийн салбарын гуравласан холбоо, хамтын нэгдмэл үйл ажиллагаа бидний хөгжлийн нэг чухал түлхүүр болно.

ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөг Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд, манай хамт олон, эрдэмтэн профессор багш, ажилтан, оюутан залуус, төгсөгч дэмжигч, хамтран ажиллагч түншлэгч талуудын оролцоотой амжилттай хэрэгжүүлснээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн шинэ хөгжлийн эхлэл болно гэдэг эргэлзэхгүй байна.

ШУТИС-ийн РЕКТОР ТӨМӨРПҮРЭВИЙН НАМНАН



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/148

Улаанбаатар хот

### Ажлын хэсэг байгуулах тухай


ШУТИС-ийн дүрмийн 4.14.14, 10.2 дахь заалтууд, Удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийг 2030 он хүртэл хөгжүүлэх Хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2. ШУТИС-ийг 2030 он хүртэл хөгжүүлэх Хөгжлийн стратеги төлөвлөгөөний төслийг 2019 оны 10 дугаар сард багтаан Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Удирдах зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал (Б.Сүхбат)-д үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн гишүүдэд ажлын үр дүнг харгалзан албан тушаалын нэг сарын үндсэн цалин хүртэл хэмжээний нэг удаагийн урамшуулал олгохыг ажлын хэсгийн ахлагч, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал (Б.Сүхбат) болон Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал (Л.Баяр-Эрдэнэ), ахлах нягтлан бодогч (Б.Алтантуяа), холбогдох бүрэлдэхүүн сургуулийн захирал, ахлах нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ

ШУТИС-ийн Захирлын 2019 оны 06-р сарын  
25-ний өдрийн 4/48 тоот тушаалын хавсралт



**ШУТИС-ийг 2030 он хүртэл хөгжүүлэх Хөгжлийн стратеги төлөвлөгөө  
боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүний нэрс**

- Ажлын хэсгийн ахлагч:** Б.Сүхбат - ХБТЭ дэд захирал
- Гишүүд:**
- Т.Намнан - ЭШХАЭ дэд захирал
  - Ж.Арслан - ХХТГ-ын дарга
  - Д.Гэрэлт-од - СБЗГ-ын дарга
  - Д.Ганбат - НБТ-ийн захирал
  - Р.Найдандорж - НБТ-ийн дэд захирал
  - Г.Баттүвшин - БАТС-ийн захирал
  - Ч.Баасандаш - БАТС-ийн ЭНБД
  - Ш.Цэнгэл - СНББА-ны ахлах мэргэжилтэн
  - М.Зулбаяр - ЭШИГ-ын мэргэжилтэн
  - Б.Мөнгөнсар - ХХТГ-ын мэргэжилтэн
  - Б.Уянга - ТДТ-ийн мэргэжилтэн
  - Н.Буянхишиг - ГУУС-ийн дэд захирал
  - С.Хаснавч - БАС-ийн ахлах багш
  - Н.Мөнхөө - БАТС-ийн дэд профессор
  - Н.Эрдэнэхүү - МХТС-ийн дэд захирал
  - Ч.Алдармаа - ХШУС-ийн тэнхимийн эрхлэгч
  - Д.Сэрдарам - БуХС-ийн дэд профессор
  - Д.Түмэнболд - ҮТС-ийн салбарын эрхлэгч
  - П.Цэрэнчимэд - НБТ-ийн мэргэжилтэн
  - Д.Ариунболор - ДБШ төслийн ҮДСБ-ийн зөвлөх
- Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:**
- Э.Халиун - ЧХШҮА-ны дарга
  - Э.Чинтунгалаг - НБТ-ийн сургалтын мастер
- Зөвлөх:**
- Д.Бадарч - ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дарга
  - Б.Очирбат - ШУТИС-ийн Захирал



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/257

Улаанбаатар хот

### Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.14.14, 10.2 дахь заалтууд, Удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэл, ШУТИС-ийн Захирлын 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А/148 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Бизнесийн ахисан түвшний сургуулийн Бизнесийн удирдлагын салбарын ахлах багш О.Тамирыг гишүүнээр нэмж оруулан ажиллуулсугай.

2. Энэхүү тушаалыг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**"ШУТИС-2030 стратеги  
төлөвлөгөө"-г батлах тухай**

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.1, Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дүгээр заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.2, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийг 2030 он хүртэл хөгжүүлэх "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.
2. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г 2020 оноос эхлэн хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай. Үүнд:
  - а. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г сурталчлан таниулах ажлыг 2020 оны турш өргөн хүрээнд зохион байгуулж ажиллах, Үүнд:
    - i. Стратеги төлөвлөгөөг нийтэд хүртээмжтэй хэлбэрээр орчин үеийн мэдээллийн бүхий л арга хэрэгслийг ашиглан сурталчлах;
    - ii. Их сургуулийн багш, оюутан, ажилтан, ажилчдад болон хамтран ажилладаг байгууллагуудад Стратеги төлөвлөгөөний үндсэн үзэл санааг ойлгуулах, таниулах ажлыг зохион байгуулах;
  - б. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхтэй холбогдсон санхүүгийн тооцоо, шаардагдах хөрөнгийн урьдчилсан хэрэгцээг 2020 оны 4 сарын 1-ны дотор гаргаж, удирдах зөвлөлд танилцуулах, жил бүрийн 4 дүгээр сарын 1-нээс өмнө стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлын тооцоо, үндэслэлийг боловсруулж, улсын төсвийн төсөлд тусгуулах санал боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэх;
  - в. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхтэй холбогдуулан ШУТИС-ийн хэмжээнд мөрдөж байгаа дүрэм, журмуудыг шинэчлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Энэ хүрээнд:
    - i. Дүрэм журмыг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг 2020 оны 1 сарын 20-ны дотор байгуулж, ажлын үр дүнг 2020 оны 5 сарын 1-ны дотор Удирдах зөвлөлд танилцуулах;

- ii. Удирдах зөвлөлийн гишүүн Д.Баяр, Б.Дамдинсүрэн, Я.Төгөлдөр нарыг энэхүү ажлын хэсэгт Удирдах зөвлөлийн төлөөллөөр оруулж ажиллуулах;
- г. “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхтэй холбогдуулан ШУТИС-ийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн талаар санал боловсруулах; Үүнд:
  - i. ШУТИС-ийн захиргааны бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн шинэчлэх санал боловсруулах ажлын хэсгийг 2020 оны 1–р сарын 20-ны дотор байгуулж, ажиллуулах;
  - ii. Ажлын хэсгийн саналыг ШУТИС-ийн Захирлын зөвлөл, Эрдмийн зөвлөлөөр 2020 оны 2-р сард багтаан хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, улмаар удирдах зөвлөлийн хуралд танилцуулах;
  - iii. Ажлын хэсэгт ажиллах Удирдах зөвлөлийн төлөөлөлд Д.Болор, Д.Цолмонбаатар, Б.Сэргэлэн нарыг оролцуулах;
  - iv. ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон салбар сургууль, харьяа байгууллагуудын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх талаар санал боловсруулах ажлыг 2020 оны 6-р сард багтаан зохион байгуулах;
- д. ШУТИС-ийн хэмжээнд ахисан түвшний сургалтыг зохион байгуулах ажлыг цоо шинэ шатанд гаргах талаар санал боловсруулах ажлын хэсгийг 2020 оны 1-р сарын 20-ны дотор байгуулж ажиллуулах, уг саналыг Удирдах зөвлөлд 3 сард багтаан танилцуулах.

ДАРГА  Д.БАДАРЧ





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/НН

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.14.14, 10.2 дахь заалтууд, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд (Алсын хараа – 2050, Шинэ сэргэлтийн бодлого)-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Цолмонбаатар  
(Эрдэм шинжилгээ, технологийн газрын захирал)

Гишүүд:

Н.Ганзориг  
(Захирлын ажлын албаны дарга)

Б.Түмэндэлгэр  
(Хяналт шинжилгээ, дотоод аудитын дарга)

Ж.Арслан  
(Судалгаа хөгжүүлэлтийн албаны дарга)

Г.Жавхлан  
(Санхүү, хөрөнгө оруулалтын албаны дарга)

М.Эрдэнэтуяа  
(Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны дарга)

М.Зулбаяр  
(Инновац, технологи дамжуулалтын төвийн захирал)

Ш.Цэнгэл  
(Санхүү, хөрөнгө оруулалтын албаны ахлах мэргэжилтэн)

Д.Ариунболор  
(Нээлттэй боловсролын төвийн лабораторийн эрхлэгч)

Р.Найдандорж  
(Нээлттэй боловсролын төвийн лабораторийн эрхлэгч)

Б.Нарантуяа  
(Барилга, архитектурын сургуулийн захирал)

367040724

О.Тамир  
(Бизнесийн ахисан түвшний сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга)

Ж.Ганчимэг  
(Бизнесийн ахисан түвшний сургуулийн дэд профессор)

Д.Үлэмж  
(Эрчим хүчний сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга)

Ч.Алдармаа  
(Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн тэнхимийн эрхлэгч)

Н.Буянхишиг  
(Геологи, уул уурхайн сургуулийн профессор)

Я.Төгөлдөр  
(Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн салбарын эрхлэгч)

П.Нямсүрэн  
(Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн ахлах багш)

Э.Энхцэцэг  
(Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн салбарын эрхлэгч)

Б.Арвинбаяр  
(Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн ахлах багш)

М.Дэлгэрмаа  
(Механик, тээврийн сургуулийн профессор)

П.Цэрэнчимэд  
(Механик, тээврийн сургуулийн дэд профессор)

Ажлын хэсгийн нарийн бичиг: (Захирлын ажлын албаны төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-ний шинэчилсэн төслийг 2023 оны 09-р сард багтаан ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Удирдах зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Эрдэм шинжилгээ, технологийн газрын захирал Д.Цолмонбаатарт үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн гишүүнээр ажилласан профессор багш нарт холбогдох журмын дагуу, ажлын гүйцэтгэлээр кредит тооцож олгохыг Сургалт, цахим шилжилтийн газрын захирал /Н.Эрдэнэхүү/, холбогдох бүрэлдэхүүн сургуулийн захирал, Сургалт, чанарын албаны дарга, Эрдэмтэн нарийн бичгийн дарга нарт зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Т.НАМНАН





**АЛСЫН ХАРАА:**

“дэлхийд үнэлэгдэх оюуны үнэ цэнийг бүтээнэ”



**ЭРХЭМ ЗОРИЛГО:**

“Эх орны хөгжлийн гарцыг тодорхойлох хүн-байгальд ээлтэй шинжлэх ухаан, технологийн мэдлэг, инновацыг бүтээх авьяас чадварын төвлөрөл байна”



**УРТ ХУГАЦААНЫ ҮНДСЭН ЗОРИЛГО:**

**2030 ОНД ДЭЛХИЙН ШИЛДЭГ 1000 ИХ СУРГУУЛИЙН НЭГ БОЛНО.**





УРИА:

“ АСУУДЛЫГ  
БҮТЭЭЛЧЭЭР  
ШИЙДЬЕ! ”



СТРАТЕГИЙН  
ЧИГЛЭЛҮҮД

### ЗАСАГАЛ, МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧЛЭЛ

1. Чадварлаг хүний нөөцийг төвлөрүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
2. Их сургуулийн үйл ажиллагааны бүх чиглэлээр цахим (дижитал) шилжилтийг хийнэ.
3. Санхүүгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, үр ашгаа дээшлүүлнэ.
4. Нээлттэй, ил тод, шударга, хариуцлагатай, хууль дээдэлсэн хамтын засаглалыг бэхжүүлнэ.

### СУРГАЛТЫН ШИНЭЧЛЭЛ

1. Дэлхийд үнэлэгдэх мэдлэг, чадвар, хандлагатай мэргэжилтнүүдийг бэлтгэнэ.
2. Багшлахуйн үр чадварыг ОУ-ын жишигт нийцүүлнэ.

#### ЗАСАГАЛ, МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧЛЭЛ

Их сургуулийн засагал, менежментийн тогтолцоог боловсронгуй болгоно.

#### СУРГАЛТЫН ШИНЭЧЛЭЛ

Хүнлэг, энэргэнгүй, бүтээлч сэтгэлгээтэй шинэ үеийн инженер, манлайлагчдыг бэлтгэнэ.

#### НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ТҮНШЛЭЛ

Тогтвортой хөгжлийг дэмжсэн, нийгмийн Хариуцлагатай түншлэгч байгууллага байна.

#### СУДАЛГААНЫ ТӨГӨЛДӨРШИЛ

Хүн-байгальд ээлтэй хөгжлийн шийдэлд хөтөлх судалгааны төгөлдөршилд хүрнэ.

#### ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ АРИЛЖААЛАЛТ

Мэдэлгийг баялаг болгох инновацийн экосистемийг хөгжүүлнэ.

#### СУДАЛГААНЫ ТӨГӨЛДӨРШИЛ

1. Олон улсын болон үндэсний хэмжээний төсөл, судалгааны ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.
2. Эрдэм шинжилгээ, судалгааны өндөр үр чадвартай хүний нөөцийг бүрдүүлнэ.
3. Эрдэм шинжилгээ, судалгааг дэмжсэн орчин бүрдүүлнэ.

#### НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ТҮНШЛЭЛ

1. Суралцагчийн үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.
2. Тогтвортой хөгжлийн зорилтод чиглэсэн, нийгмийн хариуцлагатай үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
3. Насан туршийн боловсролыг дэмжсэн сургалт, хөтөлбөрийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
4. Олон талт хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлнэ.

#### ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ АРИЛЖААЛАЛТ

1. Инновацийн соёл, хандлагыг төлөвшүүлж, энтрепренер үр чадварыг хөгжүүлнэ.
2. Аж үйлдвэр, нийгэмд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх инноваци, технологийг хөгжүүлнэ.
3. Технологи арилжаалалтыг эрчимжүүлж, инновацийн орлогыг нэмэгдүүлнэ.



# ШУТИС-203

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ


## БҮЛЭГ I

МАСТЕР  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЭРЭГЖИЛТ,  
ШИНЭЧЛЭХ ҮНДЭСЛЭЛ

# БҮЛЭГ I. МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ШИНЭЧЛЭХ ҮНДЭСЛЭЛ

## 1.1 ШУТИС-ИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

ШУТИС-ийн хөгжлийн он цагийн хэлхээс



- Барилга, архитектурын сургууль
- Бизнесийн ахисан түвшний сургууль
- Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
- Геологи, уул уурхайн сургууль
- Гадаад хэлний сургууль

- Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль
- Механик тээврийн сургууль
- Эрчим хүчний сургууль
- Мадагзал, холбооны технологийн сургууль
- Үйлдвэрлэлийн технологийн сургууль
- Хэрэглээний шинжлэх ухааны сургууль
- Эрчим хүчний сургууль
- Инженерийн ахисан түвшний сургууль
- ШУТИС - ийн харьяа Ш.Отгонбилэгийн нэрэмжит "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль
- ШУТИС - ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль
- ШУТИС - ийн харьяа (Коосан) технологийн коллеж
- ШУТИС - ийн харьяа (Политехник) коллеж
- ШУТИС - ийн харьяа (Политехник) коллеж
- ШУТИС - ийн харьяа Хөвсгөл аймаг дахь Политехник коллеж
- ШУТИС - ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургууль
- ШУТИС - ийн харьяа Дархан-Уул аймаг дахь Ерөнхий боловсролын ахлах сургууль
- ШУТИС - ийн харьяа Орхон аймаг дахь Ерөнхий боловсролын ахлах сургууль

- Барилга, архитектурын сургууль
- Геологи, уул уурхайн сургууль
- Эрчим хүчний сургууль
- Механик, тээврийн сургууль
- Үйлдвэрлэлийн технологийн сургууль
- Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
- Бизнесийн ахисан түвшний сургууль
- Мадагзал, холбооны технологийн сургууль
- Хэрэглээний шинжлэх ухааны сургууль
- Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль
- Орхон аймаг дахь технологийн сургууль
- Гадаад хэлний институт
- Е-нээлтэй институт
- ШУТИС - Коосан технологийн дээд сургууль
- ШУТИС-ийн ахлах сургууль
- Олон улсын дээд боловсрол судлалын төв

**4 эрдэм шинжилгээний хүрээлэн, 42 эрдэм шинжилгээ, судалгааны төв, 39 салбар, 7 тэнхим, 18 судалгааны профессорын баг**

- Барилга, архитектурын сургууль
- Геологи, уул уурхайн сургууль
- Эрчим хүчний сургууль
- Механик, тээврийн сургууль
- Үйлдвэрлэлийн технологийн сургууль
- Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
- Бизнесийн ахисан түвшний сургууль
- Мадагзал, холбооны технологийн сургууль
- Хэрэглээний шинжлэх ухааны сургууль
- Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль
- Орхон аймаг дахь технологийн сургууль
- Гадаад хэлний институт
- Е-нээлтэй институт
- ШУТИС - Коосан технологийн дээд сургууль
- ШУТИС-ийн ахлах сургууль
- Олон улсын дээд боловсрол судлалын төв

**4 эрдэм шинжилгээний хүрээлэн  
35 эрдэм шинжилгээ, судалгааны төв  
31 салбар  
10 тэнхим, 18 профессорын баг**

- Барилга, архитектурын сургууль
- Геологи, уул уурхайн сургууль
- Эрчим хүчний инженерийн сургууль
- Механик инженерийн сургууль
- Үйлдвэрлэлийн технологи, дизайны сургууль
- Компьютерийн техник, менежментийн сургууль
- Холбоо, мадзаллалын технологийн сургууль
- Хүнс, биотехнологийн сургууль
- Материал технологийн сургууль
- Гадаад хэлний сургууль
- Математикийн сургууль
- Хүмүүнлэгийн сургууль
- Дарханы технологийн сургууль
- Эрдэнэтийн технологийн сургууль
- Өвөрхангай технологийн сургууль
- Сүхбаатарын технологийн сургууль

**6 эрдэм шинжилгээний хүрээлэн  
29 эрдэм шинжилгээний төв**

- Барилга инженерийн факультет
- Геологи - уул уурхайн факультет
- Эрчим хүчний факультет
- Механик - технологи ба авто тээврийн факультет
- Инженер - эдийн засгийн факультет
- Мэргэшил дээшлүүлэх факультет

**13 тэнхим**

**МУИС-ийн бүрэлдэхүүн дэх ПДС**

- Нийгэм улс төрийн факультет (Ерөнхий эрдмийн факультет)
- Мэдээлэл, техник автоматжуулалтын факультет (ИЭЗФ)
- Барилгын машин механизм төхөөрөмжийн факультет (СГИФ)

**1991**

**ТИС**

**ШУТИС**

**ШУТИС**

**ШУТИС**

**ШУТИС**

**ШУТИС**

**2023**

**Политехникийн дээд сургууль**

- Барилга, архитектурын факультет
- Геологи хайгуулын факультет
- Уул уурхайн факультет
- Эрчим хүчний факультет
- Механик - технологийн факультет
- Хөнгөн, хүнсний үйлдвэрийн факультет
- Инженер - эдийн засгийн факультет
- Сантехник, гидромеханикийн факультет
- Энчээ ба оройн салбар
- Мэргэшил дээшлүүлэх салбар

**32 тэнхим**

**Техникийн их сургууль**

- Барилга инженерийн сургууль
- Геологи, уул уурхайн сургууль
- Эрчим хүчний инженерийн сургууль
- Механик технологийн сургууль
- Тээврийн сургууль
- Компьютерийн техник, менежментийн сургууль
- Мэдээллийн техникийн сургууль
- Гадаад хэлний төв
- Суурь боловсролын төв
- Дарханы технологийн сургууль

**45 тэнхим**

**Шинжлэх ухаан, технологийн их сургууль**

- Барилгын инженер, архитектурын сургууль
- Уул уурхайн инженерийн сургууль
- Геологи, газрын тосны сургууль
- Эрчим хүчний инженерийн сургууль
- Механик инженерийн сургууль
- Үйлдвэрлэлийн технологи, дизайны сургууль
- Мадагзал, холбооны технологийн сургууль
- Компьютерийн, техник, менежментийн сургууль
- Нийгэмлэгийн сургууль
- Хэлний боловсролын сургууль
- Материал технологийн сургууль
- Хүнсний инженер, биотехнологийн сургууль
- Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль
- Орхон аймаг дахь технологийн сургууль
- Сүхбаатар аймаг дахь технологийн сургууль
- Өвөрхангай аймаг дахь технологийн сургууль
- Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
- Гүнчигүүлсэн ахлах сургууль
- Олон улсын дээд боловсрол судлалын төв
- Харьяа хүрээлэн - 3
- Эрдэм шинжилгээний төв - 51

**95 профессорын баг**

**21 тэнхим**

**Шинжлэх ухаан, технологийн их сургууль**

- Барилга, архитектурын сургууль
- Геологи, уул уурхайн сургууль
- Эрчим хүчний сургууль
- Механик тээврийн сургууль
- Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
- Мадагзал, холбооны технологийн сургууль
- Үйлдвэрлэлийн технологийн сургууль
- Хэрэглээний шинжлэх ухааны сургууль
- Гадаад хэлний сургууль
- Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль
- Орхон аймаг дахь технологийн сургууль
- Бизнесийн ахисан түвшний сургууль
- Инженерийн ахисан түвшний сургууль
- Нээлттэй боловсролын төв
- ШУТИС - Коосан технологийн коллеж
- ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль

**4 эрдэм шинжилгээний хүрээлэн**

**43 эрдэм шинжилгээ, судалгааны төв**

**37 салбар**

**11 тэнхим, 18 судалгааны профессорын баг**

## 1.2 ШУТИС-ИЙН ОЛОЛТ АМЖИЛТ

### *ШУТИС –ийн тэргүүн туршлага (бенчмарк)*

ШУТИС нь аж үйлдвэрийн бүхий л салбарт инженер, техникийн дээд боловсролтой мэргэжилтэн, манлайлагч нарыг бэлтгэж эхэлснээс хойш нэгэн жаран өнгөрчээ.

Монгол Улсын дээд боловсролын салбарт ШУТИС-ийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагаа, ололт амжилт нь бусад их, дээд сургуульд үлгэр жишээ болсоор ирсэн.

- 1. Кредит систем:** Монгол Улсын дээд боловсролын салбарт анх удаа бакалавр, магистр, докторын шаталсан сургалтыг 1992-1993 оны хичээлийн жилээс эхлэн явуулж, улмаар кредитэд суурилсан сургалтын тогтолцоог нэвтрүүлж, кредит системийн онцлогийг тусгасан сургалтын хөтөлбөр боловсруулан, сургалтад нэвтрүүлж хэрэгжүүлсэн нь өнөөдөр улсын хэмжээний стандарт болон хөгжиж байна.
- 2. Их сургуулийн Удирдлагын мэдээллийн “Cloud UNiMIS” систем:** ШУТИС-ийн сургалтын зохион байгуулалт нь кредит системд шилжин орсноор, Их сургуулийн Удирдлагын мэдээллийн системийг боловсруулж, нэвтрүүлэх бэлтгэл ажил хангагдсан бөгөөд уг системээр дамжуулан үнэн, зөв мэдээллийг түгээх, удирдлагаас оновчтой шийдвэр гаргах нөхцөл бүрдсэн юм. Их сургуулийн UNiMIS v.1.0. Удирдлагын мэдээллийн системийн “Сургалтын процессын удирдлага” дэд системийг 2003 онд анх ашиглалтад оруулж, их сургуулийн өөрчлөлт, шинэчлэлийн үйл явцтай уялдуулан, клауд технологиор баяжуулан Монголдоо жишиг болгон хөгжүүлж ирсэн.
- 3. Жишиг номын сан:** Шинжлэх ухаан, технологийн төв номын сан нь 7000 кв.м талбайтай, 380 гаруй мянган ном, сурах бичиг, гарын авлага болон цахим хэлбэр бүхий олон мянган олон улсын чанартай сэтгүүл, судалгааны диссертац бүхий фондтой. Номын сан нь чөлөөт сонголттой болон цахим е-уншлагын танхим, гадаад хэл, онлайн хурлын танхим, мультимедиа студи, онлайн тестийн танхим, электрон каталогийн систем зэрэг мэдээллийн орчныг бүрэн бүрдүүлсэн байна.
- 4. Профессорын багийн систем:** Их сургуулийн хэмжээнд хийгдэж байгаа эрдэм судлалын ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, улсын болон аж ахуйн гэрээт, бизнесийн захиалгат судалгааны төсөл хэрэгжүүлэх ажлыг анхлан хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2002 оноос профессорын багийн системээр ажиллан, судалгааны төвүүдийг байгуулан, үйл ажиллагааг нь эрчимжүүлсэн. Энэхүү профессорын багийн систем нь манай улсын олон их



дээд сургуульд нэвтэрч байна.


**5. Сургалтад шинэ технологи, инновац нэвтрүүлэлт:** ШУТИС үр дүнд суурилсан сургалтын тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэхэд тэргүүлэн оролцож, олон улсын инженерийн боловсролын CDIO-гийн санаачлагд 2015 онд элсэж, шинэ арга зүй, стандартыг хөтөлбөртөө нэвтрүүлж хэрэгжүүлэн, сургалт, онлайн сургалт, нээлттэй боловсрол зэрэг орчин үеийн сургалтын чиг хандлагыг дээд боловсролын системд нэвтрүүлэхээр идэвхтэй манлайлан ажиллаж байна.

**6. Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO 21001:2018:** ШУТИС-ийн удирдлага, зохион байгуулалт болоод үйл ажиллагааг оновчлох, сайжруулах зорилгоор боловсролын байгууллагын чанарын менежментийн тогтолцоо ISO 21001:2018 олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг ШУТИС-ийн Захирлын 2018.10.17-ны А/209 тоот тушаалаар эхлүүлж, 2023.01.06-нд гэрчилгээжиж Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал, хэмжил зүйн газраас баталгаажуулсан анхны их сургууль болов.

ШУТИС-д Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO 21001:2018-ыг “Боловсролын байгууллагын удирдлага, зохион байгуулалт болон боловсролын үйлчилгээ” хамрах хүрээтэй нэвтрүүлсэн бөгөөд стандартын гэрчилгээ нь дараах нэгжид хүчинтэй. **Үүнд:**

1. Их сургуулийн захиргаа
2. Барилга, архитектурын сургууль
3. Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
4. Бизнесийн ахисан түвшний сургууль
5. Геологи, уул уурхайн сургууль
6. Механик тээврийн сургууль
7. Мэдээлэл, холбооны технологийн сургууль
8. Үйлдвэрлэлийн технологийн сургууль
9. Хэрэглээний шинжлэх ухааны сургууль
10. Эрчим хүчний сургууль
11. Гадаад хэлний сургууль
12. Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль
13. ШУТИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургууль
14. ШУТИС-ийн харьяа “Коосэн” технологийн коллеж

## ШУТИС-ийн дэлхийн түвшний ололт амжилтуудаас





2013 онд Дэлхийн эдийн засаг, бизнесийн сургуулиудын холбоо (Eduniversal)-ноос Зүүн Азийн 200 шилдэг хөтөлбөрийг шалгаруулсан ба ШУТИС-ийн Маркетингийн менежментийн магистрын хөтөлбөр 10-рт, Хүний нөөцийн менежментийн магистрын хөтөлбөр 11-рт, Санхүүгийн менежментийн магистрын хөтөлбөр 19-р байрт шалгарч, батламж гардан авсан.

2017 онд ШУТИС-ийн БАТС нь Eduniversal-аас Зүүн Азийн бүсэд нөлөөлөхүйц шилдэг 200 Бизнесийн сургуулийн тоонд багтсаныг баталгаажуулалж 2 навч (2 Palmes) бүхий гэрчилгээ олгожээ.

Монгол Улсад төдийгүй Азид анх удаа АВЕТ-ийн ETAC буюу Инженер технологийн магадлан итгэмжлэх зөвлөлөөр Цахилгаан холбоо, Утасгүй холбоо хөтөлбөрийг олон улсын хэмжээнд магадлан итгэмжлүүлэв.

Мөн ГУУС-ийн “Геодези” хөтөлбөр Олон улсын магадлан итгэмжлэлийн Герман улсын ASIIN болон Европын холбооны EUR- ACE байгууллагын зохих зөвлөмжүүдийг ханган биелүүлж, 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдэв. /2017-2022/



2018 оны 12 сард Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 107 жилийн ойн өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын зарлигаар “Монголын геологи ба ашигт малтмал” хэмээх 8 боть бүтээлд Төрийн соёрхол хүртсэн. “Монголын геологи ба ашигт малтмал” хэмээх 8 боть бүтээлийг туурвихад нөр их хөдөлмөр гаргасан Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Геологи, уул уурхайн сургуулийн ахмад багш, Ардын багш, Шинжлэх ухааны доктор, профессор Ж.Лхамсүрэн, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Шинжлэх ухааны доктор, профессор О.Гэрэл, Шинжлэх ухааны доктор, профессор Ж.Бямба, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Шинжлэх ухааны доктор, академич Р.Барсболд, Монгол Улсын Зөвлөх инженер С.Алтангэрэл, Монгол Улсын Зөвлөх инженер, Шинжлэх ухааны доктор, дэд профессор Н.Жадамба нарын эрдэмтдэд Монгол Улсын Төрийн соёрхол хүртээв.



Монголын геологийн шинжлэх ухааны 30 гаруй жилийн судалгааны материалыг 53 эрдэмтнээс бүтсэн баг нэгтгэн, хөрш зэргэлдээ орнуудын геологийн судалгаатай харьцуулж, цаашид хийгдэх судалгааны ажилд чиг баримжаа өгөх асар их баримт материалыг багцлан оруулсан нь

практикийн болон судалгаа шинжилгээний чухал ач холбогдолтой болохыг салбарын эрдэмтэн, мэргэжилтэн үнэлэнтодорхойлжээ.

Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойг тохиолдуулан, Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх зарлиг гаргаж, Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн уул уурхайн салбарын тэргүүлэх эрдэмтэн, профессоруудын туурвисан “Уул уурхайн технологи, эдийн засаг, экологи” эрдэм судлалын цогц долоон боть бүтээлд Монгол Улсын төрийн шагнал хүртээсэн.

“Уул уурхайн технологи, эдийн засаг, экологи” хэмээх 7 боть бүтээлийг Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Геологи, уул уурхайн сургуулийн зөвлөх профессор, Монгол улсын анхны ерөнхийлөгч, академич П.Очирбат, Монгол Улсын гавьяат багш С.Цэдэндорж, Монгол Улсын гавьяат багш Ж.Цэвэгмэд, Уул уурхайн хүрээлэнгийн захирал, Монгол Улсын гавьяат багш Л.Пүрэв нар туурвисан.



Энэхүү бүтээл нь геологи, уул уурхайн үйлдвэрлэлийн суурь нөхцөл болох ашигт малтмал, орд, уурхайн ашиглалтын технологи, нээлт, хаалтын менежмент, үйлдвэрлэлийн механикжуулалт, цахилгаан хангамж, автоматжуулалт, экологи, байгаль орчны хамгаалал, үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуй зэрэг өргөн хүрээтэй асуудлыг цогцоор нь судлан, онол практикийн орчин үеийн геологи, уул

уурхайн салбарын үйлдвэрлэл, эрдэм судлал, сургалтын олон талт үйл ажиллагааны хөгжлийн эдүгээ болон ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж хэрэгжүүлэхэд шинжлэх ухааны үндэслэл, онол практикийн ач холбогдолтой үнэтэй эх сурвалж болсон.

2019 онд Ази, Номхон далайн орнуудын өргөн нэвтрүүлгийн холбооноос робот зохион бүтээгч оюутан залуусын дунд зохион байгуулдаг “ABU ROBOCON” олон улсын тэмцээн “ABU ROBOCON 2019 MONGOLIA” нэртэйгээр Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан. Уг тэмцээнд Ази, Номхон далайн бүсийн 16 орны 17 баг зохион бүтээсэн роботоороо өрсөлдөж тус тэмцээнд ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн оюутны баг дэд байрт шалгарч, анх удаагаа “First Runner” цомын эзэн болсон ба 2021 онд тус амжилтаа бататгасан. “ABU Robocon 2021” олон улсын тэмцээн COVID-19 цар тахлын улмаас цахимаар зохион байгуулагдаж, ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн баг үндэсний аваргаар шалгарч, олон улсад оролцох эрхээ авсан ба 11 орны 21 баг өрсөлдсөн уг тэмцээний дэд байранд шалгарч, “First Runner” цомыг 2 дахь удаагаа хүртсэн.



Ази, Номхон далайн бүсийн орнуудын оюутан залуусын инженер сэтгэлгээ, зохион бүтээх ур чадварын тэмцээн болох “ABU Robocon” тэмцээн нь 2002 оноос зохиогдож эхэлсэн бөгөөд тухайн улсын үндэсний аваргаар шалгарсан баг нь олон улсын тэмцээнд оролцох эрхтэй болдог. Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн багууд тэмцээнд тогтмол амжилттай оролцож, үндэсний аварга багаар 17 удаа шалгарч, олон улсад эх орноо төлөөлөн оролцоод байна.

ШУТИС-ийн багийг эдгээр амжилтыг Монгол Улсын Ерөнхийлөгч



У.Хүрэлсүх хүлээн авч баяр хүргэж, амжилт хүссэн.



Азийн орнуудын их, дээд сургуулийн барилга, автозам, гүүрийн инженер мэргэжлээр суралцаж буй оюутнуудын дунд зохион байгуулагддаг “Asia Bridge 2024” тэмцээн Вьетнам улсын Кан То Их Сургууль (Can Tho University)-д амжилттай болж өндөрлөв. Уг тэмцээнд 21 багийн 150 гаруй оюутнууд залуус оролцсоноос ШУТИС, БАС-ийн Багш Б.Жавхлан, С.Энхболд нараар удирдуулсан баг нийлбэр дүнгээр “Тэргүүн байр эзэлсэн амжилтыг үзүүлсэн.

Оролцогч багууд тэмцээний дүрмийн дагуу бодит гүүрний жижгэрүүлсэн хувилбарыг тэмцээний талбайд угсарч, уралдах ба угсралтын өртөг, бүтээцийн өртөг, нийт өртөг, гоо зүй, хotoйлтын урьдчилсан тооцоо зэрэг төрлүүдэд авхаалж самбаа, ур чадвараа сорин өрсөлддөг. Манай улсын хувьд 2017 оноос эхлэн оролцож байгаа бөгөөд 2017, 2019, 2024 онуудад тус тэмцээний “Тэргүүн байр”-ын шагналыг хүртсэн.

Түүнчлэн “Asia Bridge 2025” тэмцээнийг эх орондоо зохион байгуулах эрхийг гардан аваад байна..




### 1.3 “ШУТИС-2030” СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2020-2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

ШУТИС-ийг 2030 онд дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болох урт хугацааны үндсэн зорилго дэвшүүлсэн бөгөөд энэ зорилгын хүрээнд 2020 онд “ШУТИС 2030” Стратеги төлөвлөгөө боловсруулсан. Стратегийг 26 зорилт бүхий тэргүүлэх 5 чиглэлээр тодорхойлон, нийт 20 KPI буюу гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтэд харгалзах 103 хэрэгжүүлэх стратегийг, 105 явцыг хэмжих үзүүлэлтээр стратеги төлөвлөгөөний үр дүнг хэмжихээр төлөвлөсөн.

Стратеги төлөвлөгөөний 2020-2022 оны хэрэгжилтийн явцын үзүүлэлтээс харахад зарим үзүүлэлтийн хэмжээс тодорхойгүй, арга хэмжээ нь харилцан адилгүй цар хүрээтэй төлөвлөгдснөөс биелэлтийг хэмжихэд хүндрэлтэй нөхцөлүүд үүссэн байна. 2020-2022 оны хувьд стратеги төлөвлөгөөний явцыг дүгнэхэд суурь түвшнээс өссөн үзүүлэлттэй 60, суурь түвшнээс өсөөгүй 31, суурь түвшинг тодорхойлох боломжгүй (PI дангаараа тодорхойлогдох боломжгүй) 14 үзүүлэлттэй байна. Мөн дэлхий нийтийг хамарсан цар тахлын үе энэхүү стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх үетэй давхацсан нь сөрөг нөлөөлөл үзүүлсэн.

Тайлант хугацааг Covid-19 цар тахлын үетэй холбогдуулан, 2 жилийн дунджаар тооцоолон, стратеги төлөвлөгөөний биелэлтийг суурь түвшнээс ахисан ахиц дэвшлээр үнэлсэн бөгөөд стратегийн тэргүүлэх чиглэл тус бүрээр дараах үр дүн гарсан.



Стратегийн тэргүүлэх чиглэлд харгалзах хэрэгжүүлсэн стратегийн тоо, хэрэгжилтийн дундаж хувь

Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг 2022 оны гүйцэтгэлээр гарган харуулав.

*Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлтүүд KPI-ийн биелэлт*

№	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ KPI	2019 ОНЫ СУУРЬ ТҮВШИН	2022 ОНД ХҮРЭХ ҮР ДҮН	2022 ОНД ХҮРСЭН ҮР ДҮН
1	Гадаад суралцагчдын (оюутан солилцоогоор ирсэн тоо орно) эзлэх хувь	<0.2%	0.50%	5.1%
2	Гадаад багшийн нийт багшид эзлэх хувь	<0.02%	4%	<0.003%
3	Суралцагчдад олгосон тэтгэлгийн эзлэх хувь	<0.1%	0.10%	0.5%
4	Гадаад хэл дээр явагдах бакалаврын сургалтын хөтөлбөрийн тоо	0	10	0%
5	Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	38%	47%	46.55%
6	Олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн санд бүртгэлтэй бүтээлийн нэг багшид оногдох тоо	0.6	2	0.2
7	ШУТИС-ийн эзэмшилтэй оюуны өмчийн тоо	12	150	197
8	Үндэсний болон олон улсад идэвхтэй патентын тоо	3	10	150%
9	Лицензийн гэрээний тоо	0	2	50%
10	Гарааны бизнесийн тоо	2	5	0
11	Нийт орлогод судалгаа, инновацын орлогын эзлэх хувь	12%	25%	12%
12	Нийт зардалд судалгаа, инновацад зарцуулсан зардлын эзлэх хувь	8.20%	20%	8.20%
13	Гүйцэтгэх засаглалын үнэлгээ (ашигт ажиллагааны түвшин)	-	%	-
14	Хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуулийн тоо (чансаагаар олон улсад эхний 500-д байх)	<28	40	32
15	Суралцагчийн сэтгэл ханамжийн үнэлгээ	-	3.0<	3.0<
	Гадаад суралцагчийн сэтгэл		3.0<	3.0<

	ханамжийн үнэлгээ			
	Хүний нөөцийн (багш, ажилтан) сэтгэл ханамжийн үнэлгээ		3.0<	4.4<
	Эцэг эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамжийн үнэлгээ		3.0<	3.0<
	Ажил олгогчийн сэтгэл ханамжийн үнэлгээ		3.0<	3.0<
16	Бакалавр ба ахисан түвшний (магистр, доктор) суралцагчийн тооны харьцаа	9:01	9:01	9.96:01
17	Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь	<40%	50%	65%
18	Багш, суралцагчийн тооны харьцаа	1:16	1:15	94%
19	Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхөөс суралцаж буй суралцагчийн эзлэх хувь	3%	4%	75%
20	Оюутны байранд амьдрах шинээр элсэгчдийн нийт суралцагчид эзлэх хувь	24.50%	27%	27%

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээний хувьд ерөнхий зорилтуудыг хангахад чиглэсэн болон тухайлсан нэр бүхий төсөл хөтөлбөрүүдийн холимог шинжтэй байгаа нь хэрэгжилтийг дүгнэхэд төвөгтэй байдал үүсгэсэн. Тиймээс стратегийн тэргүүлэх зорилтуудыг хангахад чиглэсэн нийтлэг бөгөөд хугацааны цагалбар баримжаатай төлөвлөлт шаардлагатай гэдэг нь харагдаж байна. Мөн түүнчлэн гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдийг үнэлэх суурь түвшинг тогтоосон аргачлалуудыг тодорхой болгон, дараагийн сайжруулалтыг хийхдээ суурь, зорилтот түвшнийг тооцох аргачлалыг тодорхой заах, үр дүнг тооцохдоо өнгөрсөн оны суурь түвшнээс ахисан хувь хэмжээгээр тооцох нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.





# ШУТИС-2030


СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

## БҮЛЭГ II

“ШУТИС 2030” СТРАТЕГИ  
ТӨЛӨВЛӨГӨӨГ  
БОЛОВСРУУЛАХ  
ҮЙЛ ЯВЦ, ХАМТЫН  
ОРОЛЦОО

## БҮЛЭГ II. “ШУТИС-2030” СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ, ХАМТЫН ОРОЛЦОО

Орчин үед их сургуулийн үүрэг өөрчлөгдөж, шинэ ойлголт, шинэ санаагаар солигдох цаг үе нэгэнт иржээ. ШУТИС-ийг 2020-2030 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг үе шаттай авч хэрэгжүүлсэн. Үүнд<sup>1</sup>:



\* Үргэлжлэл дараагийн нүүрт

1 Жишиг болгон судалсан сургуулиуд: Korea Advanced of Science and Technology (KAIST), Massachusetts Institute of Technology (MIT), Rutgers University, City University of Hong Kong, Humboldt University of Berlin

## ҮЙЛ ЯВЦ



## ҮЙЛ АЖИЛЛАГАА







# ШУТИС-203


СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ



## БҮЛЭГ III

“ШУТИС-ИЙН ХӨГЖЛИЙН  
ФИЛОСОФИ

## БҮЛЭГ III. ШУТИС-ИЙН ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ



**УРТ ХУГАЦААНЫ ЗОРИЛГО:**  
2030 онд дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болно.  
By 2030, we will become one of the Top 1000 Universities in the world

**УРИА:**  
“АСУУДЛЫГ БҮТЭЭЛЧЭЭР ШИЙДЬЕ!”  
Creatively design complexity

**ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ:**

- **Эх орны хөгжлийн гарцыг тодорхойлох:** Өнөөг хүртэл хөгжиж ирсэн шинжлэх ухаан, технологийн дэвшлийг нүүдэлчдийн өв, соёл, сэтгэлгээгээр баяжуулан хөгжүүлэх, дэлхийн бусад их сургууль, судалгааны байгууллагатай хамтран ажиллаж, эх орон, бүс нутгийн хөгжлийн гарцыг тодорхойлох нь бидний эрхэм зорилго байна. Монгол Улсын нийгэм, эдийн засаг тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанчаар шийдвэрлэхийн төлөө ШУТИС-ийн төгсөгч, суралцагч, хамтрагч байгууллага, судлаач профессор, багш ажилтан бид мэдлэг, чадвар, сэтгэл зүтгэлээ зориулан ажиллана.
- **Хүн-байгальд ээлтэй:** Бид нүүдлийн өв соёлыг өнөөгийн өндөр технологийн оролцоотойгоор хөгжүүлж, илүү өндөр үнэ цэнийг бүтээхэд манлайлан оролцож үеийн үед хүн-байгалийн шүтэлцээг эрхэмлэн ажиллаж, амьдрах учиртай. Монгол нүүдэл нь хүн төрөлхтний олон төрлийн нүүдлийн

язгуур байж, биет болон оюуны соёлын үзүүлэлт, үнэлэмжээр дахин давтагдашгүй чанар агуулдаг. Монгол нүүдэлчид байгаль эхээ хайрлан хамгаалах, түүний халдашгүй дархан байдал, эх ундаргыг ариг гамтай өнө удаан ашиглах, өсгөн үржүүлэх шударга жам ёсыг баримтлан ирсэн. Хүн-байгалийн харилцаанд байгаль, хүн хоёрын аль нэг нь хохиролгүй байж, байгаль өөрийн аясаар нөхөн сэргээгдэж, түүний даац, чадавхад нь нийцүүлэн хүмүүс баялгаас нь зохистой хэмжээгээр хүртэж, амьдрах орчноо сайжруулж байхыг өвөг дээдэс маань бидэнд өвлүүлэн ирсэн билээ. Тиймээс ШУТИС-ийн хамт олон бид энэ агуу өв соёлыг эрхэмлэн үнэ цэнийг бүтээх үйлсээр манлайлагч байхыг эрмэлзэнэ.

- **Дэлхийд үнэлэгддэг оюуны үнэ цэн:** Эв нэгдэл, эрч хүч, хүнлэг сэтгэл, задгай сэтгэлгээ, хүн байгалийн хүйн холбоотой амьдрал ахуй бол нүүдэлчин соёлтой монголчууд бидний үнэ цэн юм. Үүнийг хүн төрөлхтний бий болгосон шинжлэх ухаан, технологи, инновацын шилдэг мэдлэг, туршлагаар баяжуулан дэлхийн иргэн хэмээн үнэлүүлэх ур чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, дэлхийн хэмжээнд өрсөлдөх шинэ санаа, мэдлэг, технологийг бүтээх хүсэл тэмүүлээр бид тасралтгүй урагшилна. ШУТИС-ийн судлаач, оюутан, эрдэмтэн профессорууд олон улсад хүлээн зөвшөөрөгдөх шилдэг шийдлийг бодитоор бий болгогч, түүнийгээ тасралтгүй хөгжүүлэгч нь байна. Бид дэлхийд үнэлэгдэх оюуны үнэ цэнийг бүтээдэг судалгааны их сургууль болно.





# ШУТИС-203

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

## БҮЛЭГ IV

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ  
БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

## БҮЛЭГ IV. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ (SWOT ШИНЖИЛГЭЭ)

ШУТИС нь 2030 онд дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болох урт хугацааны үндсэн зорилго тавьсан. Уг зорилгыг амжилттай биелүүлэхэд туслах оновчтой стратегийг томъёолохын тулд ШУТИС-ийн гадаад (PESTLE, PORTER анализ), дотоод хүчин зүйлсийг судалж, SWOT (strengths – давуу тал, weaknesses – сул тал, opportunities – боломж, threats – аюул, эрсдэл) шинжилгээг хийв.

### ДАВУУ ТАЛ

ШУТИС нүүдэлчин соёл иргэншилтэй Монголын ард түмнийг орчин үеийн инженерийн боловсрол, мэдлэг, сэтгэлгээтэй болгоход манлайлах үүрэг гүйцэтгэж ирсэн. ШУТИС-ийн давуу тал нь инженер, технологийн салбарт бүх шатны хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг Монголын цорын ганц төрийн өмчийн их сургууль юм. Үе үеийн шилдэг, чадварлаг, нэр хүндтэй профессор, багш, судлаач, элсэгч, суралцагч, төгсөгчийн тоогоор улсдаа тэргүүлдэг, хамгийн өргөн цар хүрээнд үйл ажиллагаа явуулдаг сургууль юм.

#### 1. ШУТИС-ийн академик нэр хүнд

- Эрчим хүч, геологи, уул уурхай, мэдээлэл холбоо, механик инженер, барилга архитектур, түүх археологи, хөнгөн, хүнс үйлдвэрлэлийн технологи зэрэг салбарт сургалт, судалгаа, хамтын ажиллагаагаар улсдаа тэргүүлэх байр суурьтай.
- Монгол, ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, Тайван, АНУ, Турк, Польш, Итали, Австрали, Болгар, Бельги, Порьугали, Польш, Чех, Латви зэрэг улсад магистр, доктор (Ph.D, Sc.D)-ын зэрэг хамгаалсан 452 (багш-380, ажилтан-72) орчим чадварлаг, нэр хүндтэй багш, судлаач, ажилтан ажилладаг.
- MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн 5, судалгааны 35, сургалт, судалгаа хосолсон 58, туршилт сорилтын 12, сургалтын 120 орчим лабораторитой.

Эдгээрээс онцолбол: Биомеханикийн судалгааны лабораторид материалын физик, механик шинж чанарыг турших, металл хайлах, цутгуурын лабораторид хатуу болон өнгөт металлд химийн шинжилгээ хийх, өндөр температурт хайлуулах, үүлэн тооцооллын лабораторид мэдээллийн технологийн бүхий л үйлчилгээ үзүүлж, турших, хүнс судлалын эрдэм шинжилгээний төвийн лабораторид биотехнологийн болон хүнсний молекул биологийн судалгааг олон улсын стандартын түвшинд гүйцэтгэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

- ШУТИС нь жилд дунджаар 50 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны 1,8 тэрбум орчим төгрөгийн төсөл, 70 гаруй аж ахуйн 2,5 тэрбум орчим төгрөгийн санхүүжилт бүхий гэрээт ажлыг хэрэгжүүлдэг.
- ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургууль нь дэлхийн бизнесийн сургуулиудын холбоо - “Eduniversal” олон улсын байгууллагаас чансаагаараа 2 навч (2 Palmes Of Excellence - Good Business School With Strong Regional Influence) хүртэж, дэлхийн шилдэг 1000 бизнесийн сургуулийн нэг болсон.
- Геологи, уул уурхайн сургуулийн эрхлэн гаргадаг “*Mongolian Geoscientist*” электрон сэтгүүл нь олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн сан **Scopus**-д бүртгэлтэй. Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн эрхлэн гаргадаг “*Journal of Applied Science and Engineering A*” электрон сэтгүүл, Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн эрхлэн гаргадаг “*Journal of ICT Focus*” электрон сэтгүүлүүд нь олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн сан **Dimention** -д бүртгэлтэй, Эрчим хүчний сургуулийн эрхлэн гаргаж байгаа “*Journal of Energy Transition*” электрон сэтгүүл Олон улсын эрдэм шинжилгээний мэдээллийн сан **DOI, Google scholar**-д тус тус бүртгэлтэй байна. Одоо ШУТИС-д 4 цахим сэтгүүлийн платформ ажиллаж байна.

## 2. Түншлэл, хамтын ажиллагаа

- Сургалт, судалгаа, инновацын хамтын ажиллагааны чиглэлээр шинжлэх ухаан, боловсрол, төр, хувийн хэвшлийн байгууллагатай олон талт түншлэлийг өрнүүлэн ажилладаг. Тухайлбал: Нийслэлийн ЗДТГ, Дулааны цахилгаан станц-4 ТӨХК, Шинжлэх

ухаан, технологийн сан, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Оюу толгой ХХК, Рио Тинто компани, Эрдэнэс Тавантолгой ХК, Таван богд групп, MCS групп, МАК ХХК зэрэг томоохон байгууллагатай хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг.

- Гадаадын 30 орчим орны 250 гаруй их дээд сургуультай сургалт, судалгааны хамтын ажиллагааг хөгжүүлж, БШУЯ, JICA байгууллагын “Инженер, технологийн дээд боловсрол төсөл”, БШУЯ, БНСУ-ын ЗГ-ын “МХТС-ийн чадавхыг бэхжүүлэх төсөл”, “Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын мэргэжилтнийг чадавхыг бэхжүүлэх төсөл”, “Монголын хот байгуулалтын салбарын дээд боловсролын чадавхыг бэхжүүлэх S-Quad” төсөл, Европын холбооны “Erasmus+” гэх мэт олон улсын томоохон төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Олон улсын байгууллагатай хамтран, эрдэм шинжилгээний бага хурал, семинар, үзэсгэлэн тогтмол зохион байгуулан оролцож байна.

### 3. Чанарын баталгаажуулалт

- Сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг чухалчилж, хөндлөнгийн байгууллага (БМИҮЗ, ASIIN, ABET, ACBSP, EUR-ACE)-аар магадлан итгэмжлүүлдэг.
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх судалгаа боловсруулалт, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж нөөцтэй.
- Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001, ISO 21001 болон лабораторийн ISO 17025 зэрэг олон улсын стандарт нэвтрүүлсэн.
- Төгсөлтийн ажил, судалгааны өгүүлэл, эрдэм шинжилгээний илтгэл, бүтээл гүйцэтгэхдээ оюуны өмчийн хуулбарлалт шалгах программ хангамжийг нэвтрүүлсэн.

### 4. Нээлттэй, онлайн дэд бүтэц

- Боловсролын хэрэгцээг орон зай, цаг хугацаанаас шалтгаалахгүйгээр уян хатан, олон хувилбартай, нээлттэй, хүртээмжтэй, чанартай, үр ашигтайгаар хангах нээлттэй боловсролын тогтолцоог бий болгож байна.

- Цахим, зайн, нээлттэй сургалтын дэд бүтцийг тогтмол хөгжүүлж, сайжруулдаг.
- Сургалтын кредит систем болон Монгол Улсын дээд боловсролын салбарт дэлхийн жишигт нийцсэн сургалтын үнэлгээний системийг нэвтрүүлсэн.
- Их сургуулийн удирдлагын мэдээллийн UNIMIS систем, эрдэм шинжилгээний нэгдсэн дэд системийг шинээр хөгжүүлж нэвтрүүлэн, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт арга технологийг ашиглаж байна.

## **5. Инновацтай холбоотой туршлага, нөөц**

- Судалгаа, инновацын дэд бүтцийн суурь орчин нөхцөл бүрдсэн. Эрдэм шинжилгээний 4 хүрээлэн, эрдэм шинжилгээ, судалгааны 42 төв, судалгааны 35 лаборатори, судалгааны 18 профессорын баг ажиллаж байна.
- 2015 оноос “Монголын инновацын 7 хоног” арга хэмжээг санаачилж, улсын хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг.
- Оюутан залуусын техник ур чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, орчин үеийн инновацын тэргүүлэх технологи (AI-хиймэл оюун ухаан) нэвтрүүлэх чиглэлээр Ази, Номхон далайн бүсийн орнуудын оюутан залуусын роботын тэмцээнд 2002 оноос оролцож, үндэсний аваргаар 16 удаа шалгарч, эх орноо төлөөлөн Ази, Номхон далайн бүсийн орнуудын олон улсын тэмцээнд оролцсоноос “ABU Robocon Ulaanbaatar-2019” олон улсын тэмцээнд Монгол Улс 1-р байр (ШУТИС-Цахим алт баг), “ABU Robocon Fiji-2020” олон улсын тэмцээнд 2-р байр (ШУТИС-Pro mech баг) тус тус эзэлсэн амжилтыг үзүүлсэн.
- Инженерийн зохион бүтээх үйл ажиллагааг хөгжүүлэх, инженерчлэлийн инновац, шинэ бүтээл оновчтой саналыг дэмжсэн эрдэм шинжилгээний хурал, сургалт, үзэсгэлэн, улсын /CAD/CAE/CAM/-ын олимпиад зэрэг үйл ажиллагааг багтаасан “Монгол инженер” арга хэмжээг 2017 оноос санаачлан, тогтмол амжилттай зохион байгуулж байна.

- 2000 оноос эхлэн дизайны мэргэжлээр сурч буй оюутнуудын чөлөөт сэтгэлгээ, уран бүтээлийн онцлогийг харуулах, бүтээлч хандлагыг дэмжих, дизайныг тодорхойлсон бодлого концепцийг нийтэд түгээх, сургалтын онцлогийг таниулах зорилготой “Алтан хулгана” арга хэмжээг жил бүр тасралтгүй зохион байгуулдаг.
- Эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагааг хичээлийн 8-р байранд төвлөрүүлэн байршуулж, судалгаа инновацын орчинг бүрдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна.

## 6. Байршил

- Монгол Улс нь Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашин, төр, нийгмийн тогтолцооны өөр өөр системийн зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын уулзварт оршдог. Евроазийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших геостратегийн чухал энэ байршил нь 2 том гүрний эдийн засгийн сонирхол, харилцааг судлах, хамтран ажиллах судлаач, суралцагчдыг татах байршлын давуу тал юм.
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд нь тархсан байршилд байгаа хэдий ч ихэнх сургууль, номын сан, судалгааны нэгдсэн төвүүд нь Улаанбаатар хотын төвд байрладаг.

## СУЛ ТАЛ

Бид глобалчлал болон техник технологийн үсрэнгүй хөгжлийн нөлөөгөөр тасралтгүй, хурдтай өөрчлөгдөж буй орчин нөхцөлд дэлхийн шилдэг 1000 сургуулийн эгнээнд ороход дараах сул талыг арилгах шаардлагатай байна.

### 1. Барилга, байгууламж, дэд бүтэц

- Ажиллах, суралцах орчин, нөхцөл хуучирсан. Анги, танхимын ашиглалт, үйлчилгээ хангалтгүй, байр ашиглалтын менежмент сул, ариун цэвэр, эмх цэгц, гоо зүйн шаардлага хангалтгүй.

- Нийтийн үйлчилгээ (эрүүл мэнд, банк санхүү, спорт заал, цайны газар, харуул хамгаалалт, цэвэрлэгээ, оюутны байр, бусад худалдаа үйлчилгээ)-ний чанарын сайжруулалт хангалтгүй.
- Мэдээллийн урсгал удаашралтай, механик ажиллагаа ихтэй, цаг их зарцуулдаг.
- Сургалт, судалгааны лабораториудын ашиглалт, хамтын ажиллагаа хангалтгүй, нээлттэй биш, менежмент сул байгаа нь салбар дундын судалгаанд саад учруулдаг.
- Суралцагчдын ая тухтай байдал, сургалт, судалгааны орчин нөхцөл, хэрэглэгдэхүүн зэргийг бүрэн хангах кампус байхгүй тул тэднийг татахад томоохон саад болж байна.

## **2. Сургалтын хөтөлбөр**

- Тухайн мэргэжлийн ур чадварын эрэлт хэрэгцээ, ирээдүйн чиг хандлагад нийцүүлэн хөтөлбөрийг шинэчлэх, хэрэгжүүлэх бодлого оновчтой бус.
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлсэн, энтрепренёршип боловсрол олгох хичээлүүдийг хөтөлбөрт тусгаагүй.
- Хөтөлбөрийн давхардлууд гардаг.
- Бүрэлдэхүүн сургуулиуд хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх зохицуулалтыг бодлогоор хэрэгжүүлдэггүй.
- Эрэлттэй мэргэжлийг дэмжих, элсэлтийн тоог нэмэх талаар уян хатан бодлого байхгүй.
- Улс орны хөгжлийн гарцыг тодорхойлоход өндөр ач холбогдолтой брэнд хөтөлбөрүүдийг ШУТИС-д бий болгох боломж, нөөц байгаа ч бодлогоор хэрэгжүүлдэггүй.

## **3. Суралцагчийн чанар**

- Суралцагчдын хандлага, төлөвшил, зөөлөн ур чадвар хангалтгүй.
- Дотоодын болон гадаадын шилдэг суралцагч, оюутныг татах, суралцуулах эрх зүйн орчин хангалтгүй.
- Төгсөгчид нь ажил олгогчдын хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэхэд үнэлж дүгнэлт хийж, эргэх холбоотой ажиллах тал дээр муу.



#### 4. Багш, судлаач, профессор

- Дотоодын болон гадаадын шилдэг багш, судлаач, профессор татан ажиллуулах бодлого, зохицуулалт сул.
- Багш, судлаачид нь олон улсын чансаа өндөртэй сэтгүүлийн шаардлагад нийцсэн судалгаа хийж, хэвлүүлэх чадвар сул.
- Багш, ажилтнуудын англи хэлний чадвар сул.
- Ахисан түвшний сургалт, судалгааны орчин, соёл бүрэн төлөвшөөгүй.
- Залуу багш, судлаачдын практик дадлага, туршлага сул.

#### 5. Санхүүжилтийн эх үүсвэр, хамтын ажиллагаа

- Дэлхийн түвшний авьяаслаг судлаач, суралцагчдын цөмийг үүсгэх, шинэ технологийн судалгаа хийх, суурь судалгааг санхүүжүүлэх хөшүүргийг сургууль өөрөө санхүүжүүлэх боломжгүй. Судалгааны санхүүжилт дутмаг, орлогын олон талт эх үүсвэргүй.
- Гадаадын их дээд сургуулиудад суралцаж байгаа багш, оюутнуудыг сургуульдаа эргэн ирж ажиллах, тэднээр дамжуулан гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх талаарх зохицуулалт, менежмент сул.
- Багш, судлаач, эрдэмтэд хувийн хэвшлийнхэнтэй хамтарч ажиллаж байгаа ч үүнийг бодлогоор дэмжих, урамшуулах эрх зүйн орчин төлөвшөөгүй, ил тод нээлттэй бодлого баримталдаггүй.
- Бакалаврын түвшний сургалт түлхүү явуулж орлогын эх үүсвэрээ бүрдүүлдэг тул сургуулийн санхүү энэ түвшний элсэн суралцагчдаас шууд хамааралтай.

#### 6. Сургуулийн засаглал, менежмент

- Багш, судлаачдыг судалгаа, эрдэм шинжилгээний өгүүллээ чансаа өндөртэй сэтгүүлд хэвлүүлэхэд идэвхжүүлэх шагнал урамшууллын систем, бодлого зохицуулалт сул.
- Тогтвортой хөгжлийн зорилтуудад хамаарах судалгаа, ЭШ-нд одоогоор онцлон баримталсан бодлого байхгүй.
- Багаар хамтарч ажиллах соёл сайн төлөвшөөгүй. Салбар дундын судалгаа, ЭШ-ний хамтын ажиллагаа сул.

- Багш, судлаачийн ажлын төрөл, хэлбэр түүнээс хамаарах ажлын ачааллын оновчтой систем бүрдээгүй, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн систем бүрэн нэвтрээгүй.
- Магистр, докторын оюутныг бүтэн цагийн судлаач хэлбэрээр ажиллуулах механизм байхгүй. Магистр, докторын оюутанд тэтгэлэг, грант олгох санхүүгийн боломж муу.
- Академик эрх чөлөөг дэмжих эрх зүйн зохицуулалт, систем сул хөгжсөн.
- Хүний нөөцийг сонгон шалгаруулж, тогтвортой ажиллуулах бодлого сул, ажлын гүйцэтгэлийг бодитоор үнэлэх тогтолцоо бүрдээгүй.
- БСШУЯ Дэлхийн түвшний судалгааны их сургуулиудын чансааг тогтоодог албан ёсны байгууллагатай (Times Higher Education) хамтарч Монгол улсын их дээд сургуулиудад эрэмбэ тогтооход улсдаа гуравдугаарт жагссан нь нэр хүндэд сөрөг нөлөөтэй.
- Оюутнууд сургуулиа орхих, удаашралтай суралцах, хувийн сургууль руу шилжих үзэгдэл их байдаг.

## АЮУЛ

### 1. Төрийн дэмжлэг, бодлого

- Төрийн дэмжлэг сул, төр гаргаж байгаа бодлого хөтөлбөрүүдийнхээ хэрэгжилтийг хянаж, хариуцлага тооцдоггүй.
- “Дээд боловсролын салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд их дээд сургуулиуд дэлхийн түвшний судалгааны их сургууль болон хөгжих нөхцөлийг бүрдүүлэх зорилтуудыг өргөн хүрээтэйгээр тусгаж өгсөн ч хэрэгжилт хангалтгүй.
- Дээд боловсролын байгууллагын чадавхыг бэхжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын залгамж халаа, тогтвортой байдлыг хангахад улс төрийн намуудын оролцоо их байдаг нь урт хугацааны бодлогод сөрөг нөлөөтэй.
- Монгол улсад Олон улсын их дээд сургуулийн хөгжлийн суурь болсон “Triple-Helix Model of Innovation” буюу Инновац хөгжүүлэлтийн төр-хувийн хэвшил-их сургуулийн гурвалсан

холбоос загварыг идэвхтэй дэмжин хэрэгжүүлэх бодлого, зохицуулалт байхгүй байгаа нь инновац, технологи дамжуулалтыг амжилттай хөгжүүлэхэд томоохон саад болж байна.

- Төрийн өмчийн их сургуулиуд нь дээд боловсролын тухай хуулийн хүрээнд дэргэдээ сан байгуулах боломжтой боловч төвлөрсөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, өсгөх нөхцөл хязгаарлагдмал, эрх зүйн хувьд боломжгүй.
- БШУЯ-ны сургалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг шаардлага, бодлого зохицуулалт нь тогтворгүй, оновчгүй.

## **2. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт**

- Дээд боловсролын байгууллагын удирдлагын багийн томилгоонд улс төрийн нөлөө ихтэй, мерит зарчим мөрдөгдөх нөхцөлийг хязгаарладаг, сайн засаглал хэрэгжүүлэхэд саад болдог.
- Дээд боловсролын байгууллагын сайн засаглалд төр засгийн бодлого, олон нийтийн оролцоо, эрдмийн хамт олны удирдлага зэргийг зохистой байдлаар тусгасан загварыг олон улсад байдаг ч Монголд үүнийг хэрэгжүүлдэггүй.

## **3. Санхүүгийн төлөвлөлт**

- Төрөөс баримтлах урт хугацааны хөгжлийн баримт бичгүүдэд ойрын 10 жилд ДНБ-нд эзлэх эрдэм шинжилгээний зардлыг үе шаттай нэмэгдүүлэхээр тусгасан ч Монгол Улсын эдийн засгийн өсөлт болон макро эдийн засгийн үзүүлэлтүүд нь тийм ч таатай бус байгаа нь төрөөс дээд боловсролын байгууллагуудыг дэмжих бодлого бодит байдал дээр хэрэгжих боломж муутай.
- Их дээд сургуулиудын үйл ажиллагааг мөнгөн болон бусад хэлбэрээр дэмжих Эндаумент (Endowment) хэлбэрийн “хувийн сан”-гууд ховор.

## **4. Хүний нөөцийн төлөвлөлт**

- Чадварлаг, авьяаслаг судлаач, багш, суралцагчийн төлөөх өрсөлдөөн ширүүссэн тул судалгаа, ЭШ-ний ажлын туршлага өндөртэй, чадварлаг судлаач, багш нараа гадаад, дотоодын бусад байгууллага болон өрсөлдөгч нарт алдах эрсдэл өндөр.

- Багшийн карьерын зураглал, түүнд тохирсон цалин, урамшуулал, үнэлгээ, ажлын гүйцэтгэлийг уялдуулдаггүй бөгөөд хүний нөөцийн төлөвлөлт хангалтгүй.

## **5. Академик төлөвлөлт**

- Монголд инновац, судалгааны талаарх мэдээллээ хуваалцах, харилцан суралцах, хамтран ажиллах соёл төлөвшөөгүй.
- Зохиогчийн эрх, патентын тухай хуулийн дагуу оюуны өмчийг хамгаалах асуудал сул, олон нийтийн дунд зохиогчийн эрхэд мөнгө төлөн худалдан авах сонирхол бага байдаг нь шинэ мэдлэг, бүтээл, инновац бий болж, хөгжихөд саад болж байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанар муу, төгсөгчдийн мэдлэг боловсрол харилцан адилгүйгээс элсэгчдийн “зөөлөн ур чадвар” буюу аливаа асуудлыг задлан шинжлэх, үнэлж дүгнэх, шийдвэр гаргаж, шинийг бүтээх дээд эрэмбийн (ахисан түвшний) ур чадвар сул, төлөвшил хангалтгүй байна.
- Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос 2021-2025 онд 17-18 насныхны тоо одоогийнхоос 5 хүртэлх хувиар нэмэгдэнэ гэсэн тооцоолол байгаа нь цаашдаа дотоодын их сургуульд элсэгчдийн тоо цөөрөх магадлалтай байна.
- Өрсөлдөөн зөвхөн Монгол Улсаар хязгаарлагдахгүй, глобал түвшинд өссөн. Суралцагчдад дээд боловсрол эзэмших, мэргэжлийн ур чадварыг олж авах, дээшлүүлэх сонголт хийх боломж их байна. Үүнд: Монголын болон гадаадын их дээд сургууль, сургалтын төв, онлайн сургалт гэх мэт.

## **6. Суралцахуй, судалгааны орчин (кампус төлөвлөлт)**

- Дэмжих үйлчилгээний байгууллагууд (хоол, хамгаалалт, номын дэлгүүр, банк гэх мэт)-ыг төрийн эрх бүхий байгууллага сонгон шалгаруулдаг нь зарим талаар чанаргүй үйлчилгээ бий болох нөхцөлийг бүрдүүлж байна.
- Онлайн орчинд ажиллах нь олон зүйлийг хөнгөвчилж байгаа ч мэдээллийн аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй.

## 1. Дээд боловсролын талаарх төрийн дэмжлэг

- “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024”-т тусгаснаар 2024 он гэхэд Монгол Улсын 4-өөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг 100 сургуулийн эгнээнд хүргэх, мөн “Дээд боловсролын шинэчлэлийн зураглал”, “Чанарын шинэчлэлийн бодлого” болон “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-т судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх, бодит дэмжлэг үзүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.
- Шинээр батлагдсан Дээд боловсролын тухай хуулиар дээд боловсролын байгууллага болон тэнд ажиллагч багш, судлаачид нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, технологи, инновацын бүтээгдэхүүн, оюуны өмчөө хамгаалуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, гарааны компанийн үйл ажиллагаанаас орлого олох, орлогоос хувь, ногдол ашиг хүртэх талаар тодорхой зааж өгсөн тул судалгаа шинжилгээний үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах хууль эрх зүйн суурь нөхцөл бүрдсэн.
- Дээд боловсролын тухай хуулийн 32.2.2-т заасны дагуу улс орны нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ач холбогдол бүхий засгийн газрын захиалгат судалгаа, шинжилгээ, дэвшилтэт технологи дамжуулалт, инновацын хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхэд төрөөс санхүүгийн дэмжлэг авах боломжтой болсон.
- Монгол Улсын хөгжлийн бодлого (Алсын хараа 2050) болон Боловсролын бодлогод шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжилд дээд боловсролын сургалтын байгууллагын оруулах хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлэх, орон нутаг дахь бүс нутгийн онцлог, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан өрсөлдөх чадвартай үндэсний судалгааны их сургууль байгуулах үйл ажиллагааг төлөвлөсөн.
- Нээлттэй боловсролын тогтолцоо, цахим сургалтын орчныг бүрдүүлж, чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл Монгол хүнийг хөгжүүлэхээр Монгол Улсын үрт хугацааны хөгжлийн бодлогод заасан.

- Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөнд Дээд боловсролын салбарыг 2021-2030 онд хөгжүүлэхдээ (75~80-р хуудас) чанар, хүртээмж, менежменттэй холбоотой өөрчлөлт, сайжруулалт, шинэчлэлтийн 3 зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүнгийн хамт тусгасан. ШУТИС-ийн эрхэм зорилго, алсын хараа, урт хугацааны хөгжлийн бодлого үүнд нийцсэн.
- Хөдөө орон нутгийн их дээд сургуулиудыг дэмжих бодлого төрөөс баримталж байгаа нь Эрдэнэт, Дархан, Өмнөговь, Хөвсгөлд байрлах ШУТИС-ийн харьяа, бүрэлдэхүүн сургуулиудыг түшиглэн судалгаа инновацыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.
- Хөдөө аж ахуйн салбарт хувьсгал хийх төрийн дэмжлэг явагдаж байгаа тул ШУТИС энэ салбарт инженер технологийн шийдэлд суурилсан судалгаа, шинжилгээг хөгжүүлэх боломжтой.

## 2. Технологийн дэвшил

- Аж үйлдвэрийн 4-р хувьсгалын эрин үед хиймэл оюун ухаанд суурилсан шинэ технологи, робот, машин сургалт зэрэг дижитал, мэдээллийн технологийн хэрэглээ нийгэм эдийн засгийн бүх хүрээнд чухал үүрэгтэй болж, ажлын байрны өөрчлөлтийг хүчтэй бий болгож байна. Технологийн орчны энэ өөрчлөлт хандлагыг дагаж, бид мэдээллийн технологи, түүнд суурилсан үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгосноор олон давуу тал бий болох боломжтой юм.
- Орчин үеийн мэдээллийн технологийн хөгжил нь хэрэглэгчдэд технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох боломжийг бүрдүүлсэн.
- Мэдээллийн технологийн салбарын тасралтгүй хурдацтай өөрчлөлт хөгжлийн үр дүнд уламжлалт шаталсан /hierarchical/ хэлбэртэй бус матрицан, тойрог гэх мэт шинэ төрлийн бүтцийг байгуулах боломж олгосон.
- Судалгаа, ЭШ-тэй холбоотой мэдлэг, чадвараа сайжруулах, мэргэжлийн зэргээ ахиулах боломж бүхий төлбөртэй болон төлбөргүй онлайн сургалт, платформ хөгжиж байна.

- Өнөө үед хүн төрөлхтний шинжлэх ухааны хэл хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн англи хэлийг сурах болон англи хэл дээр судалгааны ажлаа бичихэд нь туслах төрөл бүрийн онлайн, дижитал үйлчилгээ нэвтэрсэн.

### 3. Хэрэглэгч, глобалчлал, түншлэл

- Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос гаргасан тооцооллоор 2030 он гэхэд Монгол Улсын хүн ам 4 сая хүрэх төлөвтэй байгаа бөгөөд энэ дотор 40-өөс дээш насныхны эзлэх хувь өндөр байна. Насжилт ихсэж байгаа нь эдгээр насныхны хувьд ажлын байран дээр ур чадварын дутагдал, хоцрогдол үүсгэдэг. Тиймээс дээд боловсролын байгууллагад ахисан түвшний боловсрол олгох, мөн мэргэжил дээшлүүлэх (executive course) сургалт санал болгох боломж үүсэж байна.
- Ирэх 20 жилд их дээд сургуульд элсэх элсэгчдийн тал хувийг зөвхөн Хятад (одоо-22%), Энэтхэг (одоо-10%) гэсэн 2 улсын элсэгчид эзэлнэ гэсэн таамаглал байна. Энэхүү өсөлтийн гол шалтгаан нь эрдмийн зэрэг авснаар амьдралынхаа туршид олох орлого, боломжууд нэмэгдэнэ гэж итгэсэн хүний тоо улам бүр нэмэгдэж байгаа болон мэдлэгт суурилсан дэлхийн эдийн засгийн хэрэгцээ шаардлагаас үүдэж байгаа юм. Бидэнд глобалчлалын нөлөөгөөр зөвхөн Монгол Улсаас биш олон улсаас, ялангуяа монгол туургатан улсуудаас суралцагчдыг элсүүлэх боломж бүрдсэн.
- Хятад улс гадаадад сурсан оюутнуудад төрөөс дэмжлэг олгох, тэтгэлэгт хамруулах бодлого гаргасан нь хятад, өвөрмонгол оюутнуудыг ахисан түвшний хөтөлбөрт элсүүлэх бүрэн боломжтой болсон.
- Олон улсын улс төрийн нөхцөл байдлаас хамаарч, олон улс ОХУ-тай харилцах харилцаандаа хязгаарлалт тавьсантай холбоотой Монгол Улстай судалгаа, эрдэм шинжилгээний түвшинд хамтран ажиллах санал ихээр тавих болсон.
- Гадаад, дотоодын их сургуулиуд хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх сонирхол ихэссэн.



#### 4. Монгол орны байгалийн баялгийн нөөц

- Монгол Улсад 90 гаруй төрлийн ашигт малтмалын 1,170 орд найман мянга гаруй илэрц бүртгэгдсэн байдаг. “Ernst&Young” групп нөөцөөрөө хамгийн их байгаа Монголын 15 эрдэс баялгийн түүхий эдэд үнэлгээ хийсэн бөгөөд үүнд дурдсанаар Монгол Улс 306 тэрбум ам.долларын зэс, 128 тэрбумын нүүрс, 62 тэрбумын алт, 30 тэрбум ам.доллараар үнэлэгдэх төмрийн хүдэртэй. Тэрчлэн фосфор 28, цайр 16, уран 4.1, мөнгө 2 тэрбум ам.доллар гм. Нийт нөөцийг олон улсын судлаач, эдийн засагчид дунджаар 1.3 их наяд ам.доллар хэмээн үнэлсэн байна. Зөвхөн эрдэс баялаг төдийгүй Монгол Улс нь биотехнологи, генетикийн асар их нөөцтэй орон тул ШУТИС-д сургалтын бааз, судалгааны талбарыг хөгжүүлэх өргөн боломжийг олгож байна.
- НҮБ-ын “Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол Улсын оруулах хувь нэмэр” конвенцын баримт бичигт тусгаснаар Монгол Улс өөрийн зорилтот хувь нэмэртээ байгаль орчин, эрчим хүч, аж үйлдвэр, хөдөө аж ахуй болон хог хаягдлын салбарт 2030 он хүртэл үүрэг хүлээн, хэд хэдэн арга хэмжээг авна гэсэн нь ШУТИС сургалт, судалгааны баазаа түшиглэн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж төрөөс дэмжлэг авах боломж болж байна.





# ШУТИС-203

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

## БҮЛЭГ V

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ,  
ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

## СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ-1. СУРГАЛТЫН ШИНЭЧЛЭЛ:

Хүнлэг, энэрэнгүй, бүтээлч сэтгэлгээтэй шинэ үеийн инженер, манлайлагчдыг бэлтгэнэ.

Стратегийн зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Үр дүнг хэмжих шалгуур (KPI)		Суурь түвшин	Хүрэх үр дүн			
		Үзүүлэлт	Хэмжих нэгж		2024	2026	2028	2030
1.1. Дэлхийд үнэлэгдэх мэдлэг, чадвар, хандлагатай мэргэжилтнүүдийг бэлтгэнэ.	1.1.1 Сургалтын хөтөлбөрийн төрөл, хэлбэр, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Бакалавр оюутан болон ахисан түвшний суралцагчийн харьцаа	Харьцаа	86:14	84:16	81:17	80:20	
		2. Гадаад хэл дээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн эзлэх хувь	Хувь	0.10%	0.20%	0.50%	1%	
	1.1.2 Төгсөгчдийн эргэх холбоог сайжруулна.	3. Мэргэжлээрээ ажиллаж буй төгсөгчийн хувь	Хувь	72%	74%	76%	78%	
	1.2. Багшлахуйн үүдийг бэлтгэнэ.	1.2.1 Багшийн мэргэжлийн болон багшлахуйн үр чадварыг хөгжүүлэн нэр хүндийг өсгөх үйл ажиллагааг дэмжинэ.	4. Улс болон салбартаа онцгой хувь нэмэр оруулсан багшийн тоо	Тоо	100	150	200	250
			5. Үндсэн багш, гадаад багшийн харьцаа	Харьцаа	1:64	1:60	1:57	1:55
		1.2.2 Сургалтын материаллаг орчинг сайжруулна.	6. Гадаад оюутны эзлэх хувь,	Хувь	193:1	191:1	189:1	185:1
1.2.3 Суралцагчдад ёс зүйн зөв хандлага, соёлыг төлөвшүүлнэ.								
		<b>6 KPI</b>						

**СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ-2. СУДАЛГААНЫ ТӨГӨЛДӨРШИЛ:**

Хүн-байгальд ээлтэй хөгжлийн шийдэлд хөтлөх судалгааны төгөөлдөршилд хүрнэ.

Хэрэгжүүлэх стратегийн зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Үр дүнг хэмжих шалгуур (KPI)		Суурь түвшин	Хүрэх үр дүн		
		Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж		2024	2026	2028
2.1 Олон улсын болон үндэсний хэмжээний төсөл, судалгааны ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.	2.1.1 Олон улсын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.						
	2.1.2 Дотоодын захиалгат төсөл, гэрээт ажил хэрэгжүүлнэ.	1. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн багш, судлаачийн тоо	Тоо	94	113	118	122
	2.1.3 Их сургуулийн өөрийн санхүүжилттэй төслийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлнэ.						
2.2 Эрдэм шинжилгээ, судалгааны өндөр үр чадвартай хүний нөөцийг бүрдүүлнэ.	2.2.1 Эрдэм шинжилгээ, судалгааны өндөр үр чадвартай гадаад, дотоодын багш, судлаачдыг татна.	2. Нэг үндсэн багш, судлаачид ноогдох WoS, Scopus-т бүртгэлтэй өгүүллийн дундаж тоо	Тоо	0.11	0.20	0.35	0.50
	2.2.2 Багш, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны үр чадварыг хөгжүүлнэ.	3. WoS, Scopus-т бүртгэлтэй нэг өгүүлэлд ноогдох дундаж эшлэлийн тоо 4. WoS, Scopus-т бүртгэлтэй нийт өгүүлэлд гадаадын эрдэмтэд, байгууллагатай хамтарсан өгүүллийн эзлэх хувь	Тоо Хувь	4.9 40%	5.2 50%	5.4 55%	5.6 60%

<p>2.3 Эрдэм шинжилгээ, судалгааг дэмжсэн орчин бүрдүүлнэ.</p>	<p>2.3.1 Судалгааны лаборатори, нэгжүүдийг хөгжүүлж, тогтвортой ажиллуулна.</p> <p>2.3.2 Олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны мэдээллийн сангуудтай хамтран ажиллана</p> <p>2.3.3 Эрдэм шинжилгээ, судалгааны орчинг сайжруулахад удирдлага, багш, судлаачид хамтран ажиллана.</p>	<p>5. Нээлттэй, салбар дундын судалгааны лабораторийн нийт тоо</p>	Тоо	6.0	7.0	8.0	9.0	10.0
		<b>5 КРІ</b>						

## СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ-3. ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ АРИЛЖААЛАЛТ

Мэдлэгийг баялаг болгох инновацийн экосистемийг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратегийн зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Үр дүнг хэмжих шалгуур (KPI)		Суурь түвшин	Хүрэх үр дүн		
		Хэмжих нэгж	Үзүүлэлтийн нэр		2024	2026	2028
3.1 Инновацийн соёл, хандлагыг төлөвшүүлж, энтрепренер ур чадварыг хөгжүүлнэ.	3.1.1 Инновац, технологи, хөрөнгө босголтын (fundraising) мэргэшсэн менторуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.						
	3.1.2 Багш, судлаач, суралцагчийн энтрепренер ур чадварыг хөгжүүлнэ.						
	3.1.3 Багш, судлаач, суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх уралдаан, арга хэмжээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.						
	3.1.4 Инновацийн соёл, хандлагыг төлөвшүүлэх, оюуны өмчийг хамгаалах, арилжаалахтай холбоотой зөвлөн туслах үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.						
	3.1.5 Зохион бүтээгч багш, судлаач, суралцагчдыг дэмжих дэмжлэгийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.						
3.2 Эх орны хөгжлийн гарцыг тодорхойлох, хүн-байгальд ээлтэй технологи, инновац бий болгох санаачилгыг дэмжинэ.	3.2.1 Зохион бүтээх урлан, инновацийн туршилт, хагас үйлдвэрлэлийн материаллаг орчинг сайжруулна.						
	3.2.2 Эх орны хөгжлийн гарцыг тодорхойлох, хүн-байгальд ээлтэй технологи, инновац бий болгох санаачилгыг дэмжинэ.						
		1. Их сургуулийн эзэмшилтэй аж үйлдвэрийн оюуны өмчийн тоо	Тоо	25	40	63	100



3.2 Аж үйлдвэр, нийгэмд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх инновац, технологийг хөгжүүлнэ.	3.2.3 Шинэ технологи хөгжүүлэх, ноу хау бүтээх, дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн инновацын түншлэлийг хөгжүүлнэ.	Тоо	6	9	17	30	51	
	3.2.4 Их сургуулийн эзэмшилтэй аж үйлдвэрийн оюуны өмчийг нэмэгдүүлнэ.		2. Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн технологийн тоо	30	51			
	3.2.5 Үйлдвэрлэлд технологи нэвтрүүлсэн их сургуулийн эзэмшилтэй оюуны өмчийг үнэлж, зохион бүтээгчдэд роаялти олгох тогтолцоог бүрдүүлнэ.		3. Лицензийн гэрээний тоо	10	16	30	50	
	3.3.1 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж, технологи арилжаалалтыг нэмэгдүүлнэ.		4. Гарааны компанийн тоо	1	3	7	14	21
	3.3.2 Гарааны бизнес хөгжүүлэлт, технологи арилжаалалтыг дэмжих хатуу, зөөлөн дэд бүтцийг бэхжүүлнэ.		5. Инновац, технологи арилжаалалтын үйл ажиллагаанд зарцуулсан зардлын эзлэх хувь	0.02%	0.45%	0.45%	0.96%	1.58%
3.3 Технологи арилжаалалтыг эрчимжүүлж, инновацын орлогыг нэмэгдүүлнэ.	3.3.3 Гарааны компанийн тоог нэмэгдүүлнэ.	Хувь	0.10%	0.36%	0.81%	1.65%		
	3.3.4 Инновацын санхүүжилтийг өсгөж, роаялти орлогын ашгийг нэмэгдүүлнэ.						6. Инновац, технологи арилжаалалтын үйл ажиллагаанаас орсон орлогын эзлэх хувь	
	3.3.5 Барааны тэмдгийн ашиглалт, брэнд бараа бүтээгдэхүүний хөгжүүлэлтээс олох орлогыг нэмэгдүүлнэ.							
		<b>6 КРІ</b>						

## СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ – 4. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ТҮНШЛЭЛ:

Тогтвортой хөгжлийг дэмжсэн, нийгмийн хариуцлагаатай түншлэгч байгууллага байна.

Стратегийн зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Үр дүнг хэмжих шалгуур (KPI)		Суурь түвшин	Хүрэх үр дүн			
		Үзүүлэлт	Хэмжих нэгж		2024	2026	2028	2030
4.1 Суралцагчийн үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.	4.1.1 Суралцагчдад үзүүлэх эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.	1. Суралцагчийн үйлчилгээний хүртээмжийн өөрчлөлт	Хувь	135	4.9%	7.1%	5.3%	3.6%
	4.1.2 Суралцагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.			408	0.0%	12.7%	11.3%	10.2%
	4.1.3 Суралцагчийн өөрийн удирдлагын болон сайн дурын байууллагын үйл ажиллагааг дэмжинэ.			131	8.1%	0.5%	6.5%	5.1%
	4.1.4 Тусгай хэрэгцээт суралцагчийн суралцах, судалгаа хийх таатай орчин нөхцлийг бүрдүүлнэ.			-	3 (0%)	16.7%	4.8%	2.3%
	4.1.5 Суралцагчид олгох санхүүгийн дэмжлэгийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.			2064	7.8%	10.1%	9.2%	8.4%
4.2 Тогтвортой хөгжлийн зорилтод чиглэсэн, нийгмийн хариуцлагатай үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	4.2.1 Тогтвортой хөгжлийн зорилтод чиглэсэн үйл ажиллагааны тоог нэмэгдүүлнэ.	2. Тогтвортой хөгжлийн зорилтод чиглэсэн үйл ажиллагааны хүртээмжийн өөрчлөлт	Хувь	-	30 (0%)	5.6%	18.4%	8.9%
	4.2.3 Нийгмийн хариуцлагатай зорилтод төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлнэ.			-	31 (0%)	11.4%	7.8%	5.4%
	4.2.4 Нийгмийн соён гэгээрэл, шинжлэх ухаан, танин мэдэхүйн (STEM) боловсролд			-	65 (0%)	7.7%	13.1%	6.1%

	чиглэсэн сургалт, арга хэмжээг зохион байгуулна.								
	4.2.5 Үндэсний болон олон улсын хэмжээний уралдаан, тэмцээн, үзэсгэлэн зэрэг арга хэмжээнд багш, ажилтан, суралцагчийн оролцоо, манлайлыг дэмжинэ.		130	2.9%	10.0%	2.3%			6.7%
4.3 Насан туршийн боловсролыг дэмжсэн сургалт, хөтөлбөрийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	4.3.1 Олон нийт, элсэгчдэд зориулсан богино хугацааны сургалт, зэргийн бус хөтөлбөрийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.		-	150 (0%)	12.2%	8.8%			10.0%
	4.3.2 Төгсөгчдийн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх богино хугацааны сургалт, зэргийн бус хөтөлбөрийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	4. Насан туршийн боловсролын үйлчилгээний хүртээмжийн өөрчлөлт	-	53 (0%)	16.4%	16.4%			10.7%
	4.3.3 Хилийн чанад дахь монголчуудад зориулсан богино хугацааны, зэргийн бус хөтөлбөрийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.		-	57 (0%)	29.1%	42.7%			14.3%
	4.3.4 Байгууллагын захиалгат богино хугацааны, зэргийн бус хөтөлбөрийн сургалтын төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.		-	65 (0%)	17.1%	20.1%			14.2%
4.4 Олон талт хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлнэ.	4.4.1 Гадаад, дотоод хамтын ажиллагааны хүртээмж, үр нөлөөг дээшлүүлнэ.	Хувь	2	0.0%	25.0%	33.3%			35.0%
	4.4.2 Маркетинг, олон нийттэй харилцах үйл ажиллагааны хүртээмж, үр нөлөөг дээшлүүлнэ.	Хувь	-	0.0%	17.3%	18.5%			21.0%

	4.4.3 Төрийн бодлого, төсөл, хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилт, шинжилгээ, үнэлгээнд их сургуулийн оролцоог нэмэгдүүлнэ.	7. Төрийн бодлого, хөтөлбөр боловсруулалтад оролцон ажилласан профессор, багшийн эзлэх хувийн өөрчлөлт	Хувь	-	1.0%	2.8%	5.0%	7.5%
<b>7 КР1</b>								

## СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ – 5. ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧЛЭЛ:

Их сургуулийн засаглал, менежментийн тогтолцоог боловсронгуй болгоно.

Стратегийн зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Үр дүнг хэмжих шалгуур (KPI)		Суурь түвшин	Хүрэх үр дүн		
		Үзүүлэлт	Хэмжих нэгж		2024	2026	2028
5.1 Чадварлаг хүний нөөцийг төвлөрүүлэх бодлого хэрэгжүүлнэ.	5.1.1 Эрдмийн замналын (track) тогтолцоог нэвтрүүлнэ.						
	5.1.2 Багш, ажилтны нийгмийн баталгааг ханган, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.						
	5.1.3 Хүний нөөцийн мэргэжлийн болон хувь хүний тасралтгүй хөгжлийг хангана.	1. Хүний нөөцийн тогтвор, суурьшлын үзүүлэлт	хувь	80	85	88	90
	5.1.4 Үр дүнд суурилсан гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ.						
5.2 Их сургуулийн үйл ажиллагааны бүх чиглэлээр дижитал шилжилтийг хийнэ.	5.2.1 Мэдээллийн технологийн суурь дэд бүтцийн хүчин чадал, ашиглалтыг нэмэгдүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.	Дижитал шилжилтийн бэлэн байдлын үнэлгээ:	хувь	10	20	30	40
	5.2.2 Их сургуулийн үйл ажиллагааны бүх чиглэлд шинэ технологид суурилсан мэдээллийн системийг нэвтрүүлнэ.	2. Шинэчлэгдсэн дэд бүтцийн хувь 3. Цахим шилжилтийн үнэлгээ	хувь	10	20	40	50
5.3 Санхүүгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, үр	5.3.1 Их сургуулийн эндуамент санг байгуулж, сангийн удирдлагын үйл ажиллагааг тогтворжуулна.	4. Эндуамент сангийн хөрөнгийн өсөлт	хувь	0	10	15	20
	5.3.2 Санхүүжилтийн олон талт эх үүсвэрээс орох орлогын	5. Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаанаас олсон	хувь	5/9	10/15.	20/20	30/25

ашгаа дээшлүүлнэ.	хэмжээг нэмэгдүүллэнэ.	орлого/зардлын эзлэх хувь							
5.4 Нээлттэй, ил тод, шударга, хариуцлагатай, хууль дээдэлсэн хамтын засаглалыг бэхжүүлнэ.	5.3.3 Зардлын бүтцийг оновчилж, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлнэ.								
	5.3.4 Хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлж, өсөлтийг нэмэгдүүллэнэ.								
	5.4.1 Их сургуулийн хамтын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно.								
	5.4.2 Их сургуулийн хөгжлийн бодлогын хэрэгжилт, ахиц дэвшлийг тогтмол үнэлж, тасралтгүй сайжруулна.								
	5.4.3 Чанарын баталгаажуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, процессын сайжруулалтыг тасралтгүй хийнэ.								
		хувь	0	30	50	70	100		
		хувь	70	70	75	80	85		
		хувь	10	20	30	40	50		
		6. Их сургуулийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн дундаж хувь							
		7. Оролцогч талуудын сэтгэл ханамжийн түвшин							
		8. Эко систем бүрдүүлсэн орчны хувь							
		<b>8 КР1</b>							

